

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн засаг даргын тамгын газрын II тайлангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2023/04/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Алтай хот

2023 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр

Утас: 70483413 Цахим хаяг:
tuvshinbayarkh@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 70484055 Цахим хаяг:
erdenechimegd@audit.gov.mn

Аудитор Э.Сүнжидмаа

Утас: 80048599 Цахим хаяг: Sunjidmaae@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13, Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.03.09 № 104

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Засаг даргын тамгын газрын II тайлангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол дагуу Говь-Алтай аймгийн Засаг даргын тамгын газрын II тайлангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар санхүүгийн төсвийн хөрөнгөөр бэлэг худалдан авсан, Элсэлтийн ерөнхий шалгалтад өндөр оноо авсан сурагчдын сургалтын төлбөрийг төсвөөс төлсөн, сургалт зөвлөгөөний зардалд хөрөнгө зарцуулсан 28.4 сая төгрөгийн зөрчил нь Төрийн хэмнэлтийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, АДБОУС 1250, иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын онцолсон хэсэг

Тайлант онд 28.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө буурсан байна энэ нь урьдчилж гарсан зардал болох 15.2 сая төгрөг, 13.6 сая төгрөгийн номыг Боловсрол соёл шинжлэх ухааны газарт хүлээлгэн өгсөнтэй холбоотой.

Аудитын гол асуудал

“Алтай залуус-2022” арга хэмжээг зохион байгуулж, 18 сум 2 тосгоны 700 гаруй ганц бие залуус хамрагдсан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

0702000233

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	28,760.3	
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		
Нийт хөрөнгийн дүн	28,760.3	
Нийт өр төлбөрийн дүн		
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	28,760.3	
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	28,760.3	
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	1,304,784.2	1,342,220.1
Үйл ажиллагааны зардлын дүн	1,276,023.9	1,370,980.4
Үйл ажиллагааны үр дүн	28,760.3	(-28,760.3)
Үйл ажиллагааны бус үр дүн		
Үйл ажиллагааны нийт үр дүн	28,760.3	(-28,760.3)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл		
Тайлант оны үр дүн	28,760.3	(-28,760.3)
Эцсийн үлдэгдэл		
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,304,784.2	1,342,220.1
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,304,784.2	1,342,220.1
Үйл ажиллагааны ЦМГ	0	0
Хөрөнгө оруулалтын ЦМГ	0	0
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	0	0
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		
Урсгал зардал	1,342,220.1	1,098,067.7
Хөрөнгийн зардал		
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		
Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,342,220.1	1,098,067.7
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		

Гурав. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 74.5 сая төгрөгийн алдаа¹, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг зөрчсөн 74.5 сая төгрөгийн гүйлгээг аудитын явцад гүйлгээг нөхөн шивүүлж, зөрчлийг арилгасан.

Үүнд:

- ✓ **Хууль тогтоомжтой холбоотой:** Бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөрийн дүн татварын нэвтрэлтийн нэгдсэн системд бүртгээгүй 74.5 сая төгрөгийн гүйлгээг системд нөхөн шивүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт 28.4 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 12.7 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 15.7 зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар, 1 заалт бүхий зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлсэн байна.

5.1 Төлбөрийн акт

- ✓ Элсэлтийн ерөнхий шалгалтад 800 оноо авсан 4 сурагчийн сургалтын төлбөрт 12.7 сая төгрөгийг олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" заалтыг зөрчсөн, үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

5.3 Албан шаардлага

- ✓ Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд аж үйлдвэрийн сургалт, семинар хурал, зөвлөгөөнийг зохион байгуулахад 15,721.6 мянган төгрөг зарцуулсан. зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-т "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх," 15.2.4-т "бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх зэргээр бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зардлыг хэмнэх" заалтыг зөрчсөн, үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/												
Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлс эн		Үүнээс				Зөвлөм ж	
							Залруулсан		Залр уула агүй			
		То о	Дүн	Тоо	Дүн	То о	Дүн	Тоо	Дүн	То о	Д үн	Тоо
Бэлтгэн нийлүүлэгчэ эс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээни й төлбөрийн дүн	1	74,494.4	1	74,494.4	-	-	1	74,494.4	-	-	-	-

¹ Тайлагнасан санхүүгийн тайлангийн үзүүлэлт, тайлагнасан байвал зохих үзүүлэлтийн хоорондын зөрүү. Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

татварын нэвтрэлтийн нэгдсэн системд дутуу шивсэн												
Дүн	1	74,494.4	1	74,494.4	-	-	1	74,494.4	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/											
	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлаг а тооцуулах албан		Хууль, хяналтын байгууллаг	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаал	Тоо	Дүн
Элсэлтийн ерөнхий шалгалтад амжилт гаргасан хүүхдүүдийн сургалтын төлбөрийг төсвөөс төлсөн	1	12,680.0	1	12,680.0	-	-	-	-	-	-	-	-
Сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг зохион байгуулсан	1	15,721.6	-	-	-	-	1	11,721.6	-	-	-	-
Дүн	3	28,401.6	2	16,680.0			1	11,721.6	-	-	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1	-	-	-	1	-	-
	НИЙТ	1	1	-	-	-	1	-	-

СОНСОХ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ

№1

2023 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Алтай хот

Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны дугаар сарын-ны өдрийн 11 цагт цахим хэлбэрээр сонсох ажиллагааг явууллаа.

Сонсох ажиллагаанд байгууллагын захиргааг төлөөлж: Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга албан тушаалтай Ш.Эрдэнэбат

Нягтлан бодогч албан тушаалтай Н.Наранцэцэг нар оролцов.

Сонсох ажиллагааны бүрэлдэхүүнээс татгалзал бий эсэх: Байхгүй

Татгалзаж байгаа шалтгаан: _____

Бүрэлдэхүүнийг зөвшөөрч байна. Гарын үсэг _____

Сонсох ажиллагаа явуулах болсон шалтгаан: Захиргааны шийдвэрийн хууль, эрх зүйн үндэслэл, тухайн асуудлын талаарх шалтгаан нөхцөл, үндэслэлийг танилцуулав.

Аудитор Аймгийн засаг дарга тамгын газрын II тайлангийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитын асуудлын бүртгэлийг танилцууллаа. Асуудлын бүртгэлтэй холбоотой асууж тодруулах зүйл байна уу.

Хариулт	асуудлын	бүртгэлтэй	танилцлаа.
---------	----------	------------	------------

.....			
.....			
.....			
.....			

Сонсох ажиллагааг 11 цаг 30 минутад дуусгав.

Сонсох ажиллагаанд оролцсон:

Захиргааны төлөөлөл: Аудитор

/Э.Сүнжидмаа/

Оролцогч

Засаг даргын тамгын газрын дарга
Нягтлан бодогч

/Ш.Эрдэнэбат/
/Н.Наранцэцэг/